



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 04 өдөр

Дугаар А/44

Аргатай

Эзэмшил газрын нэгж талбарыг
нэгтгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 31 дүгээр зүйлийн 31.3, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 5.1.3.1 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Тус сумын Аргатай 3 дугаар багийн нутаг дэвсгэрт Соёлын төвийн зүүн талд (Дөш 4-418 тоот) байршилтай Хаан банк 2693321 регистрийн дугаартай банк санхүүгийн байгууллагын зориулалттай 197м²(0.0197га) газар, (Дөш гудамж 4-418а тоот) байршилтай банк санхүүгийн байгууллагын зориулалттай 285 м²(0.0285 га) газрыг нэгтгэж 482 м²(0.0482 га) болгон банк санхүүгийн байгууллага зориулалтаар нь 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигчийн газрын гэрчилгээг шинэчлэн олгож, газар эзэмших гэрээ байгуулж ажиллахыг газрын даамал (Т.Шуухааз), хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Х.Сарангэрэл) нарт даалгасугай.

3. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч "Хаан банк" - ны эрхлэгч (Д.Бурмаа)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулж сумын Засаг даргын 2017 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн А/47 дугаар захирамж, 2017 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/51 дүгээр захирамжуудын Хаан банкинд холбогдох хэсэг, мөн газар эзэмших 000310087, 000310143 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ЗОЛЗАЯА